



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/053/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: Audit.mn Хэнтий аймаг Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энх-Амгалан Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1 Төлбөрийн акт	12
3.2 Албан шаардлага	12
3.3 Зөвлөмж	13
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25

№

418

танай

-ны №

-т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- DJI air mavic 3 pro drone, DJI микрофоныг зах зээлийн үнээс 7,600.0 мянган төгрөгөөр өндөр үнээр худалдан авалт хийсэн;
- Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 8,500.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 1,092.4 мянган төгрөг нийт 9,592.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон;
- Өмнөх онд 12,242.0 мянган төгрөгийн өвсийг зарж борлуулан авлага үүсгэж санхүүгийн тайланд тусгасан боловч авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 "төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар

зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна", 46.5.8-д "Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх", гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь улсын төсвийн хөрөнгөөр 2,054,321.8 мянган төгрөгийн усан хангамж, ариутгах татуургын байгууламж, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 549,431.9 мянган төгрөгийн барилга, байгууламж, гэрэлтүүлэг, нийт 2,603,753.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгажээ.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 112,987.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 59,052.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 53,934.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 32 зорилтын хүрээнд 250 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэл 85 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	462,758,226.14	519,130,899.00
33	АВЛАГА	14,627,365.47	29,071,171.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,385,365.47	-
33500	Бусад авлага	12,242,000.00	29,071,171.00
33510	Байгууллагаас авах авлага	-	16,829,171.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	12,242,000.00	12,242,000.00
34	УРЬДЧИЛГАА	8,000,000.00	9,722,670.00
34600	Урьдчилж гарсан зардал	8,000,000.00	9,722,670.00
35	БАРАА МАТЕРИАЛ	440,130,860.67	480,337,058.00
35100	Түүхий эд материал	913,260.00	747,500.00
35130	Эм боох материал	913,260.00	747,500.00
35400	Хангамжийн материал	279,675,400.67	291,568,358.00
35410	Бичиг хэргийн материал	22,592,975.00	17,782,075.00
35420	Аж ахуйн материал	43,210,810.67	62,759,498.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,470,000.00	1,470,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,755,170.00
35450	Барилгын засварын материал	1,230,000.00	1,230,000.00
35470	Бусад хангамжийн материал	211,171,615.00	206,571,615.00
35600	Мал амьтад	159,542,200.00	188,021,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,414,152,555.80	6,786,151,279.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,414,152,555.80	6,786,151,279.13
39200	Биет хөрөнгө	4,234,673,805.80	6,606,766,279.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,944,087,477.00	4,384,700,256.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(335,827,226.46)	(471,661,830.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	312,419,684.00	345,719,684.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(101,881,999.90)	(164,460,267.34)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	150,877,620.10	990,581,022.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,459,773.97)	(120,522,010.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,472,242.77	104,172,242.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,766,965.82)	(52,549,845.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	510,858,693.98	1,832,582,893.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	(201,105,945.90)	(241,795,865.79)
39300	Биет бус хөрөнгө	179,478,750.00	179,385,000.00
39301	Програм хангамж	1,300,000.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(981,250.00)	(1,075,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	179,160,000.00	179,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,876,910,781.94	7,305,282,178.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	28,147,371.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	28,147,371.00
41300	Өглөг	-	28,147,371.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,246,971.00
41360	Бусад өглөг	-	26,900,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	21,411,800.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	5,488,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,876,910,781.94	7,277,134,807.13
51	Засгийн газрын хувь оролцоо	4,876,910,781.94	7,277,134,807.13
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,103,713,939.94	1,103,713,939.94
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,103,713,939.94	1,103,713,939.94
51200	Хуримтлагдсан үр дүн	3,707,622,926.45	6,107,846,951.64
51210	Өмнөх үеийн үр дүн	3,627,393,389.76	3,655,676,309.31
51220	Тайлант үеийн үр дүн	80,229,536.69	2,452,170,642.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,573,915.55	65,573,915.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,876,910,781.94	7,305,282,178.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,324,317,028.00	4,102,902,498.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,082,000.00	4,102,902,498.00
120	Нийтлэг татварын бус орлого	195,082,000.00	2,654,026,319.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,082,000.00	45,128,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,332,000.00	45,128,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	183,750,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	2,603,758,319.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	5,140,000.00
122	Тусламжийн орлого	-	1,448,876,179.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,448,876,179.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,398,368,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,398,368,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	50,508,079.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	34,585,579.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,922,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,235,028.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,762,128.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,197,128.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	565,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,117,472,900.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,117,472,900.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,244,087,491.31	1,650,731,855.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,244,087,491.31	1,650,731,855.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,048,380,156.72	1,403,012,157.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,735,555.53	691,909,903.69
210101	Үндсэн цалин	311,547,750.67	348,288,434.09
210102	Нэмэгдэл	149,160,660.37	212,626,364.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,754,292.70	33,666,766.11
210104	Урамшуулал	21,012,702.70	17,014,050.00
210105	Гэрээт ажлын хөлс	49,260,149.09	80,314,288.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,160,200.36	86,257,826.43
210201	Тэтгэврийн даатгалын зардал	44,403,788.01	58,883,428.45
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,151,609.05	7,283,737.20
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,569,204.51	3,499,132.98
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,385,094.76	3,165,278.03
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	9,650,504.03	13,426,249.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,138,384.05	89,135,653.95
210301	Гэрэл, цахилгаан	10,908,824.05	23,089,393.95
210302	Түлш, халаалт	56,429,560.00	64,866,460.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,179,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,893,548.00	55,542,493.67
210401	Бичиг хэрэг	29,199,500.00	11,966,500.00
210402	Тээвэр, шатахуун	41,437,648.00	21,544,281.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,112,000.00	1,671,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,613,200.00	548,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,531,200.00	19,811,912.67
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,000,000.00	-
2105	Нормативт зардал	6,988,800.00	1,755,260.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	165,760.00
210502	Хоол, хүнс	6,988,800.00	411,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,178,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,884,900.00	24,867,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,884,900.00	-
210604	Урсгал засвар	-	24,867,400.00
2107	Томилголт, зочны зардал	16,432,000.00	16,930,000.00
210702	Дотоод албан томилголт	16,432,000.00	16,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,804,140.00	142,520,570.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,037,600.00	141,270,018.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	363,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	410,744.00	341,806.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	603,400.00	-
210807	Газрын төлбөр	686,396.00	424,296.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,342,628.78	294,093,048.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,074,560.00	63,288,470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	1,784,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,888,068.78	229,020,578.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,707,334.59	247,719,698.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	247,219,698.50
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	247,219,698.50
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	247,219,698.50
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	247,219,668.50
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	30.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,790,456.00	500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,590,456.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	187,916,878.59	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,351,878.59	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	565,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	80,229,536.69	2,452,170,642.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	80,229,536.69	2,452,170,642.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,141,167,028.00	1,460,360,179.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,332,000.00	1,460,360,179.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,332,000.00	392,471,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,332,000.00	392,471,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,332,000.00	11,484,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	380,987,900.00
122	Тусламжийн орлого	-	1,067,888,279.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,067,888,279.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,017,380,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,017,380,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	50,508,079.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	34,585,579.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,922,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,835,028.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,362,128.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,797,128.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	565,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,117,472,900.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,117,472,900.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,136,678,628.00	1,411,152,579.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,136,678,628.00	1,411,152,579.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,873,793.41	1,145,672,509.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,064,921.00	691,909,903.69
210101	Үндсэн цалин	313,933,116.14	348,288,434.09
210102	Нэмэгдэл	149,160,660.37	212,626,364.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,698,292.70	33,666,766.11
210104	Урамшуулал	21,012,702.70	17,014,050.00
210105	Гэрээт ажлын хөлс	49,260,149.09	80,314,288.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,160,200.36	83,872,460.96
210201	Тэтгэврийн даатгалын зардал	44,403,788.01	57,502,724.59
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,151,609.05	6,917,224.65
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,569,204.51	3,499,132.98
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,385,094.76	3,165,278.03
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	9,650,504.03	12,788,100.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,138,384.05	82,964,753.95
210301	Гэрэл, цахилгаан	10,908,824.05	23,089,393.95
210302	Түлш, халаалт	56,429,560.00	58,695,560.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,179,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,956,200.00	34,973,080.00
210401	Бичиг хэрэг	4,611,000.00	3,971,000.00
210402	Тээвэр, шатахуун	26,050,200.00	27,485,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,297,000.00	1,808,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045,000.00	548,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,953,000.00	1,158,900.00
2105	Нормативт зардал	1,807,100.00	1,178,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	1,178,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,254,600.00	52,765,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	28,444,800.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	-
210604	Урсгал засвар	21,311,500.00	24,320,400.00
2107	Томиллолт, зочны зардал	16,432,000.00	16,930,000.00
210702	Дотоод албан томиллолт	16,432,000.00	16,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,804,988.00	114,980,940.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,038,448.00	113,730,388.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	363,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,10,744.00	341,806.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	603,400.00	-
210807	Газрын төлбөр	686,396.00	424,296.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,255,400.00	66,098,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,775,400.00	65,300,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,480,000.00	798,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,804,834.59	265,480,069.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	264,048,869.50
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	264,048,869.50
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	264,048,869.50
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	247,219,668.50
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	16,829,201.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,887,956.00	500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	716,000.00	-
213208	Хөдөл орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,590,456.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,581,500.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	187,916,878.59	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,351,878.59	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	565,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	931,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	931,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,488,400.00	49,207,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,488,400.00	49,207,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,488,400.00	49,207,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,488,400.00	49,207,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,488,400.00	49,207,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,488,400.00)	(49,207,600.00)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,713,939.94	65,573,915.55	3,624,768,389.76	4,794,056,245.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,625,000.00	2,625,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,713,939.94	65,573,915.55	3,627,393,389.76	4,796,681,245.25
9	Тайлант үеийн үр дүн	-	-	80,229,536.69	80,229,536.69
10	2024 оны 12-р сарын 31-нээрх	1,103,713,939.94	65,573,915.55	3,707,622,926.45	4,876,910,781.94
11	2025 оны 1-р сарын 1-нээрх	1,103,713,939.94	65,573,915.55	3,707,622,926.45	4,876,910,781.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(51,946,617.14)	(51,946,617.14)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,713,939.94	65,573,915.55	3,655,676,309.31	4,824,964,164.80
19	Тайлант үеийн үр дүн	-	-	2,452,170,642.33	2,452,170,642.33
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,103,713,939.94	65,573,915.55	6,107,846,951.64	7,277,134,807.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,025,680,200.00	779,713,331.50	245,966,868.50
12	Татварын бус орлого	1,025,680,200.00	779,713,331.50	245,966,868.50
120	Нийтлэг татварын бус орлого	8,300,000.00	9,552,800.00	(1,252,800.00)
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	8,300,000.00	9,552,800.00	(1,252,800.00)
122	Тусламжийн орлого	1,017,380,200.00	770,160,531.50	247,219,668.50
122005	Төсвөөс санхүүжих	1,017,380,200.00	770,160,531.50	247,219,668.50
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,406,668,100.00	1,160,701,231.50	245,966,868.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,406,668,100.00	1,160,701,231.50	245,966,868.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,401,505,200.00	1,160,201,231.50	241,303,968.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,000,000.00	691,909,903.69	113,090,096.31
210101	Үндсэн цалин	368,198,000.00	348,288,434.09	19,909,565.91
210102	Нэмэгдэл	249,048,000.00	212,626,364.85	36,421,635.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,470,000.00	33,666,766.11	9,803,233.89
210104	Урамшуулал	45,209,200.00	17,014,050.00	28,195,150.00
210105	Гэрээт ажлын хөлс	99,074,800.00	80,314,288.64	18,760,511.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,625,100.00	83,872,460.96	16,752,639.04
210201	Тэтгэврийн даатгал	68,425,100.00	57,502,724.59	10,922,375.41
210202	Тэтгэмжийн даатгал	8,050,000.00	6,917,224.65	1,132,775.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,025,000.00	3,499,132.98	525,867.02
210204	Ажилгүйдлийн даатгал	4,025,000.00	3,165,278.03	859,721.97
210205	Эрүүл мэндийн даатгал	16,100,000.00	12,788,100.71	3,311,899.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,686,200.00	82,964,753.95	10,721,446.05
210301	Гэрэл, цахилгаан	32,440,600.00	23,089,393.95	9,351,206.05
210302	Түлш, халаалт	58,695,600.00	58,695,600.00	40.00
210303	Цэвэр, бохир ус	2,550,000.00	1,179,800.00	1,370,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,330,300.00	35,160,380.00	10,169,920.00
210401	Бичиг хэрэг	8,000,000.00	3,621,000.00	4,379,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,000,000.00	27,485,880.00	2,514,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,200.00	2,345,800.00	2,132,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045,000.00	548,800.00	496,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,807,100.00	1,158,900.00	648,200.00
2105	Нормативт зардал	4,807,100.00	1,178,000.00	3,629,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807,100.00	1,178,000.00	3,629,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,916,200.00	86,975,500.00	8,940,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,173,100.00	52,655,100.00	3,518,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	-	943,100.00
210604	Урсгал засвар	28,800,000.00	24,320,400.00	4,479,600.00
2107	Томилолт, зочны зардал	17,000,000.00	16,930,000.00	70,000.00
210702	Дотоод албан томилолт	17,000,000.00	16,930,000.00	70,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,907,000.00	123,134,732.90	36,772,267.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,406,800.00	121,884,180.00	34,522,620.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	363,450.00	650,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	341,806.90	194,593.10
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	121,000.00	124,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	-	740,400.00
210807	Газрын төлбөр	963,500.00	424,296.00	539,204.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,233,300.00	38,075,500.00	41,157,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,548,900.00	37,277,500.00	34,271,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,684,400.00	798,000.00	6,886,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,162,900.00	500,000.00	4,662,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,162,900.00	500,000.00	4,662,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,162,900.00	500,000.00	4,662,900.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(380,987,900.00)	(380,987,900.00)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380,987,900.00	380,987,900.00	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	380,987,900.00	380,987,900.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	39.00	39.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00	-
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	9.00	9.00	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	2.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	50,508,079.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,508,079.00
122	Тусламжийн орлого	50,508,079.00
1221	Хандив тусламж /дотоод/	50,508,079.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,508,079.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,585,579.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,922,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,678,878.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,678,878.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,678,878.00
2104	Хангамж, бараа материалын зардал	350,000.00
210401	Бичиг хэрэг	350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,306,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,306,208.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,022,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,022,670.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	16,829,201.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(16,829,201.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(16,829,201.00)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа¹ 59,052.8 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 54,521.1 мянган төгрөгөөр зөрүүтэй
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Гэрэлтүүлэг төсөл, арга хэмжээний үндсэн хөрөнгийг данс бүртгэлд 4,500.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг санхүүгийн тайланд залрууллаа.

Тайлант онд аудитаар нийт 53,934.4 мянган төгрөгийн зөрчил илэрч 4 албан шаардлага хүргүүлжээ.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн зөрчилд дараах албан шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

- 1 ширхэг DJI air mavic 3 pro drone, DJI микрофоныг 14.5 сая төгрөгөөр буюу зах зээлийн үнээс 7,600.0 мянган төгрөгөөр өндөр үнээр худалдан авалт хийж төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлжээ.

- Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалд 8,500.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 1,092.4 мянган төгрөг нийт 9,592.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна”, 46.5.8-д “ Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх” заалтуудыг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлжээ.

- Өмнөх онд 12,242.0 мянган төгрөгийн өвсийг зарж борлуулж авлага үүсгэж санхүүгийн тайланд тусгасан боловч авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Нийцлийн аудитын хүрээнд илэрсэн 24,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг тайлангийн 4.4.2-т тусгасан болно.

3.3 Зөвлөмж

Аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах зөвлөмжийг хүргүүлээ.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 56 нэр төрлийн 138 ширхэг хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах эсэх саналыг бэлтгэж, шийдвэрлүүлэх.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 29,434.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдэл зөрүүтэй тооцсон	1	54,521.1			1	54,521.1	1	54,521.1				
Үндсэн хөрөнгийг орлогод дутуу бүртгэсэн	1	4,531.8			1	4,531.8	1	4,531.8				
Дүн	2	59,052.8			2	59,052.8	2	59,052.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Зах зээлийн үнээс өндөр үнээр хөрөнгө худалдаж авсан	1	7,600.0			1	7,600.0							
Зардлын эдийн засгийн ангилал баримтлаагүй	1	9,592.4			1	9,592.4							
Авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	12,242.0			1	12,242.0							
Дүн	3	29,434.4			3	29,434.4							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн	1	24,500.0			1	24,500.0		-
Дүн	1	24,500.0			1	24,500.0		-
Нийт дүн	4	53,934.4	3	29,434.4	1	24,500.0		-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 82-А2360453

Чингис хот

ХЭА-2026/053/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 ширхэг DJI air mavic 3 pro drone, DJI микрофоныг 14,500,000 /арван дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгөөр буюу зах зээлийн үнээс 7,600,000 /долоон сая зургаан зуун мянган/ төгрөгөөр өндөр үнээр худалдан авч, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зах зээлийн үнээс өндөр үнээр хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга С.Бат-Эрдэнэ-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 83-А/236/0453
ХЭА-2026/053/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Онцгой байдлын аврах, эрэн хайх албаны ажилтны усны хувцас, хэрэгслийг 24,500,000 /Хорин дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгөөр тендер зарлалгүй шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана", Засгийн газрын "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа – 20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9."Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендер зарлалгүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЗДТГ-ын дарга С.Бат-Эрдэнэ-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 84-А/2360453

Чингис хот

ХЭА-2026/053/НА-СТА-ТШЗ

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 8,500,000 /найман сая таван зуун мянган/ төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 1,092,400 /нэг сая ерэн хоёр мянга дөрвөн зуун/ төгрөг нийт 9,592,400 /есөн сая таван зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна", 46.5.8-д " Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх" заалтуудыг тус тус зөрчиж "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.6-г "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга С.Бат-Эрдэнэ-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 85-А 2360453

Чингис хот

ХЭА-2026/053/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өвс, тэжээлийн нөөцөөс 2024 онд 12,242,000.00 /арван хоёр сая хоёр зуун дөчин хоёр мянган/ төгрөгийн өвсийг иргэдэд худалдаж авлага үүсгэсэн боловч тайлант онд авлага барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга С.Бат-Эрдэнэ-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН